**МОНГОЛ УЛС**
**ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2023 оны 07 сарын 27 өдөр Дугаар А/413 Мөрөн сум

Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3, 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.4,2.1.6, 4.1, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 08 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2023 оны XV дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Эмчилгээ хийлгэхэд санхүүгийн дэмжлэг хүссэн Мөрөн сумын иргэн Х.Оюунгэрэлд 500.000 (Таван зуун мянган) төгрөг, санхүүгийн дэмжлэг хүссэн Политехникийн коллежид 3,000.000 (Гурван сая) төгрөг, Жүдо бөхийн өсвөр үеийн аварга шалгаруулах тэмцээнд оролцох тамирчин О.Тэлмүүн, Т.Отгонжаргал нарт нийт 1,000.000 (Нэг сая ) төгрөгийн дэмжлэгийг тус тус үзүүлсүгэй.

2.Дээрх зардлын 4,500.000 (Дөрвөн сая таван зуун мянган) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс, гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Батбилгүүн)-д зөвшөөрсүгэй.

3.Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Хуягбаатар-т даалгасугай.

ДАРГА П.ЛХАГВАЖАВ

Захирамж-2023

6710010033